

**“Шуудангийн нэгдсэн кодын формат. Ерөнхий шаардлага MNS 5880:2008”,  
 “Нэгдсэн хаягжуулалт. Хаягийн бичвэрт тавих шаардлага MNS 6275:2016”,  
 “Шуудангийн хаяг MNS 5971:2009” стандартуудыг нэгтгэж шинэчлэн  
 боловсруулах ажлын даалгавар**

<p>Боловсруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага</p>	<p>1. Манай улсад хотжилттой холбоотой хаягжилтын асуудал хурцаар тавигдаж цахим шуудангийн үйлчилгээнд виртуал хүргэлтийн цэг, хаягийн асуудал хурцаар тавигдаж байна. Иймд шуудангийн хаягийн бичвэрийн стандартыг нэн яаралтай ДШХ-ны S42 стандарттай нийцүүлэн шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.</p> <p>2. Хаягжилтын талаархи "Шуудангийн нэгдсэн кодын формат. Ерөнхий шаардлага MNS 5880:2008", "Шуудангийн хаяг MNS 5971:2009", "Нэгдсэн хаягжуулалт. Хаягийн бичвэрт тавих шаардлага MNS 6275:2016" стандартуудыг нэгтгэн нэг болгосноор зөрүүтэй ойлголтуудыг нэтгэх, хэрэглэхэд хялбар болно.</p>
<p>Стандартын хамрах хүрээ /юуг тодорхойлох/</p>	<p>Шинээр боловсруулагдах стандарт нь хаягийн бичвэрийн нэгдсэн шаардлагыг тогтоох учраас улсын хэмжээнд мөрдөгдөнө.</p> <p>Энэхүү стандартаар хаягийн бичвэр дэх дараалал, шуудангийн нэгдсэн кодын формат болон шуудангийн хаягийн бичвэрийг латин үсгээр галиглах асуудлыг тодорхойлно.</p>
<p>Бусад оронд хэрэгжсэн байдал</p>	<p>Улс болгон өөрийн газар нутаг, хүн амын төвлөрөлтэйгээ холбоотойгоор хаягжилтын асуудлыг шийддэг.</p> <p>Харин шуудангийн илгээмжин дээрхи хаягийн бичвэрийн нэгдсэн стандартыг ДШХ тогтоож мөрдүүлдэг.</p>
<p>Стандартыг мөрдөх газрууд</p>	<p>Хаягийн бүртгэл хийдэг болон шуудангаар үйлчлүүлэгч иргэн аж ахуйн нэгж</p>
<p>Ууялдуулах баримт бичиг, стандарт</p>	<p>Шуудангийн тухай хууль, Хаягжилтын тухай хууль</p>